

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(2022 оны жилийн эцсийн байдлаар)

Орхон аймаг

2022.12

Бодлогын баримт бичигт тусгагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	№	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2021/	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1.Ерөнхий чиг үүргийн нэр: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ							
Үндсэн чиг үүргийн нэр: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.	1	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, хөгжүүлэх, байгууллагын болон бусад тэтгэлгээр жил бүр 1-2 албан хаагчийг нийгмийн эрүүл мэндийн ахисан түвшний сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	8	10	Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны А/253 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц дэх Нийгмийн эрүүл мэндийн төв нь 9 эмч, эмнэлгийн мэргэжилтний орон тоотойгоор аймгийн хүн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлага арга зүйгээр ханган ажилласан. Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн төвд 2 мэргэжилтэн шинээр ажилд авч хангалтыг нэмэгдүүлсэн. Тайлант хугацаанд 50 эмч, эмнэлгийн мэргэжилтэн сургалтад хамрагдаж <u>чадавхжсан</u> . Үүнд: - “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” зөвлөгөөнд 4 мэргэжилтэн - Томуугийн үндэсний зөвлөгөөнд 3 - Сургагч багшаар 2 эмч - Дархлаажуулалтын мэргэжил олгох сургалтад 9 сувилагч - Зайн болон танхимын сургалтад 32 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамрагдлаа. Сум, өрхийн эрүүл мэндийн төв болон сургууль цэцэрлэгийн 40 эмч, сувилагчийн уулзалт ярилцлага, сургалтыг 15 удаа зохион байгуулж шинэ мэдээлэл, арга зүйгээр хангасан.	100
	2	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх	Лабораторийн тоо	0	1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа лабораторид болон Эрдэнэт клиникийн лабораторид шаардлагатай тохиолдолд ПГУ шинжилгээ хийж	100

		чиглэл болгон хөгжүүлж лабораторийн шинжилгээ бүхий нотолгоонд суурилсан тандалт судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлэх				ажилласан. Нөөцөд үнэлгээ хийхэд ПГУ шинжилгээний дагалдах хэрэгсэл, урвалж оношлуур, фильтертэй хошуу, түргэвчилсэн шинжилгээний оношлуурын нөөц тус тус 2-3 сарын нөөцтэй байна. Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл, КОВИД-19-ын ПГУ болон түргэвчилсэн оношлуурыг Эрүүл мэндийн газрын даргын тушаалуудаар олгож нөөцийг нэмэгдүүлснээр 3-4 сарын нөөцтэй байна. Тайлант хугацаанд коронавируст халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 22302 иргэнд, Бх-ПГУ шинжилгээг 10422 иргэнд хийснээс коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн. Лабораторийн чадавх өмнөх оноос 8,5%-аар нэмэгдэж 88,5% болсон байна.	
3	Хүн амын дунд эрүүл мэндийн суурь судалгааг хийж, түүнд түшиглэсэн эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх	Суурь судалгааны тоо, үр дүн	-	1	<p>“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд бидний хувь нэмэр, судлаач-2022” уриан дор эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж 36 илтгэл хэлэлцүүлснээс улсын хэмжээнд 2 илтгэл хэлэлцүүлэгдсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> -Ундны уснаас шалтгаалсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний сүүлийн 5 жилийн байдалд судалгаа хийж, нөлөөлж буй хүчин зүйл, цаашид авах арга хэмжээний саналыг "Усны үнэ цэнэ" аймгийн хэмжээний зөвлөгөөнд танилцуулсан. -Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндэд учруулж буй сөрөг үр дагаварт эрсдэлийн үнэлгээ хийж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгамдсан асуудлыг цагаан тоосны эрсдэлийг үнэлэх, бууруулах салбар зөвлөлийн уулзалтад танилцуулсан. -Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн 20-59 насны 250 албан хаагчийг архины хэрэглээний түвшинг тогтоох сорилд хамруулсан ба судалгааны үр дүнд 40% нь I-р түвшин, 30% нь II-р түвшин, 20% нь III-р түвшин, 10% нь IV-р 	100	

						<p>түвшний зэрэглэлд хамаарч байгаа тул III, IV-р түвшний хэрэглэгчдийг сэтгэл зүйн сургалт, эмчилгээнд хамруулсан.</p> <p>- 5 сургуулийн ахлах ангийн 885 сурагчаас "Өсвөр насны хүүхдийн сэтгэл гутрал, стресс, өөрийн үнэлгээ, цахим хамаарлын түвшин болон түүний гэр бүлийн байдал, оршин суугаа харьяалал хоорондын хамаарлын байдлыг судлахад 55.4% өөртөө итгэх итгэлтэй, 1.8% өөрийн үнэлгээ багатай, 14.4% сэтгэл гутралын хүндэвтэр түвшин, 7.9% сэтгэл гутралын хүнд түвшинд, 33.2% стрессийн түвшин өндөр, 70,9% интернэтийг эрсдэлтэй нөхцөлд ашигладаг гэсэн үр дүн гарсан байна. Иймд мэргэжлийн 11 сэтгэл зүйч 91 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, 24 төрлийн сэтгэл оношилгоонд 255 иргэн, бүлгийн сэтгэл засалд 240 иргэнийг хамруулсан үр дүнтэй байна.Хүн амын дунд эрүүл мэндийн суурь 3 судалгаанд 10,380 иргэн хамрагдаж, тандалт судалгаанд суурин хүн амын 1%-ийг хамруулж, зорилтот түвшинд хүрсэн.</p>	
	4	“Эрүүл хамт олон” ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах	ЭМДБ-ын тоо	71	73	<p>Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байр шалгаруулах болзолт шалгуур болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сурталчлан ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 74 болж, үүнээс боловсролын байгууллага 45, үйлдвэр аж ахуйн нэгж 11, эрүүл мэндийн байгууллага 10, бусад 8 байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төсвөөс 6,0 сая төгрөгийг шийдүүлсэн. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд "Өдөр бүр 30 минутыг өөртөө" аяныг өрнүүлж, эрүүл мэндээ дээдлэгч 14 ажилтныг олон нийтэд цахимаар сурталчлан 38904 иргэнд хүргэсэн байна.</p>	100
Зорилт 2. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан	5	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, үр нөлөөг дээшлүүлэн	Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундаж хувь	85,4%	85,5%	<p>Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг хүчингүй болгосон. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын тушаалуудаар 5 арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж</p>	70

сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулах		ажиллах				хэрэгжилт дунджаар 83,8 хувьтай байна. Тус арга хэмжээнүүдийн хүрээнд 267,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгаас шийдвэрлүүлэн хэрэгжүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтэд 17 удаагийн хяналтыг хийж, зөвлөмжөөр хангасан. Тушаал шийдвэрийн хэрэгжилт дунджаар 84,9% байна.	
	6	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлэх	Эрт илрүүлэг 60,4%	53,4%	55%	Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хатуурал, хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Эрт илрүүлэг үзлэг 40.5% байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 43118 буюу хамрагдвал зохих хүн амын 62,8 хувийг эзэлж, өмнөх оноос 5 хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 1.7 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 26522 буюу хамрагдвал зохих хүн амын 78,2 хувийг эзэлж, өмнөх оноос 1,3 хувиар өсч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувь онош батлагдсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 17093 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 49,6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 26,9 хувиар буурсан байна. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 2572 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 32,4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 7,6 хувиар буурсан ба 1392 буюу 86.9 хувь нь пап шинжилгээнд хамрагдсан байна. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер зөвлөмжийг 18569 иргэнд хүргэж, 3 өдөрлөгт давхардсан тоогоор 4786 иргэнийг хамруулан 6 эх бэлтгэл, 3 шторка бэлтгэн цахим хуудсаар иргэдэд хүргэсэн.	70
	7	Хүн ам, ялангуяа цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их дээд сургуульд суралцагчдад эрүүл мэндийн боловсрол	Нийт хүн амын сургалт сурталчилгаанд хамрагдсан хувь	85%	90%-аас бууруул ахгүй байх	Тайлант хугацаанд мэдээлэл, сургалт сурталчилгааг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болон цахимаар, танхимаар тогтмол хүргэн ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тайлант хугацаанд нийт 1278 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 155466 иргэнийг хамруулж, 20 төрлийн 	100

		олгох сургалт сурталчилгааны хүртээмжийг дээшлүүлэх				сурталчилгааны материалыг 9951 иргэнд түгээсэн. - Цахим хуудагт 261 төрлийн гарын авлага, шторка, зөвлөмжийг байршуулан 647002 иргэнд түгээсэн Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 2 төсөл шалгаран тус төслүүдийн хүрээнд сургалтад 6600 хүн хамрагдаж, аян, өдөрлөгт 405 иргэн оролцож, цахимаар эрүүл мэндийн зөвлөмж, сурталчилгаа 75086 иргэнд хүрсэн байна. Мөн 10 төрлийн гарын авлага 2000 ширхэг хэвлэгдэн, 10 төрлийн шторка, контент хийгдэж цахимд байршуулснаар 44351 хандалт хийгдэж, 701 иргэн хуваалцаж, 60 сэтгэгдэл бичигдсэн байна.	
Зорилт 3. Агаар, ус, хөрсний бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тандаж, бууруулах эрүүл мэндийн цогц арга хэмжээг бусад салбарын дэмжлэгтэй хэрэгжүүлэх	8	Агаар, ус, хөрсний бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах салбар хоорондын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80%-аас дээш	Орчны эрүүл мэндийн салбар хоорондын төлөвлөгөөний хэрэгжилт 82,5%-тай байна. Үүнд: - “Дэлхийн орчны эрүүл мэнд”-ийн өдрийг тохиолдуулан салбар дундын уулзалт зохион байгуулж, 3 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. - Байгаль орчны газар, Ус цаг уур орчны шинжилгээний газартай агаар бохирдуулагч эх үүсвэр болон агаарын чанарын индексийн мэдээлэл солилцон хамтран ажиллалаа. Агаарын чанарын индексийн тайланг tsag-adaag.gov.mn цахим хаягаар мэдээлж ажилласан. - Агаар бохирдуулагч эх үүсвэрээр гэр хороолол 13378, бага оврын уурын зуух 106, станц 2, хөдөлгөөнт эх үүсвэр 21600 байна. Мод 57574м3, нүүрс 791685 тн хэрэглэсэн судалгаа гарсан байна. - Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө түүнээс урьчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн сургалтад 28 эмч, орчны эрүүл мэндийн чиглэлээр 10 удаагийн сургалтад сургууль, цэцэрлэгийн удирдлага, багш, арга зүйч нарын төлөөлөл 152 хүн хамрагдсан. - Орчны эрүүл мэндийн чиглэлээр 84 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад хамруулсан. - Баян-Өндөр сумын засаг даргын тамгын газартай гэрээгээр Хувийн хэвшлийн 5 байгууллага халдваргүйтгэл, мэрэгч, шавьжгүйтгэлийг хийж гүйцэтгэж ажилласан. Тус байгууллагуудын үйл	100

						<p>ажиллагаанд 2 удаагийн зөвлөмж өгч ажиллалаа. Хаврын улиралд Баян- Өндөр сумын гэр хорооллын 14 багийн 260 өрхийн нүхэн жорлон, муу усны нүх болон 145 аж ахуйн нэгжийн 8000м3 талбайд урьдчилэн сэргийлэх халдваргүйтгэл хийгдээд байна. Намрын улиралд 477 аж ахуйн нэгж, 464 айл өрхийн 42315м2 талбайд төлбөртэй халдваргүйтгэлийг 3 төрлийн бодис ашиглан хийсэн байна.</p> <p>Ус хөрс, агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх 3 төрлийн гарын авлага, 11 төрлийн мэдээллийг 17549 хүнд хүргэсэн.</p>	
9	Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааг өргөжүүлэх	Судалгааны тоо	1	1	<p>Сүүлийн 10 жилд аймгийн ус хангамжийн эх үүсвэр, өргөх, дамжуулан шахах насос станц, усан сан, ус түгээх байр, хэрэглэгчийн цэгээс нийт 1583 дээжинд хийсэн шинжилгээний дүнд үнэлгээ дүгнэлт өгөхөд нян судлалын шинжилгээгээр 98.8% нь ундны усны стандартын шаардлага хангасан байна.</p> <p>Ундны уснаас шалтгаалсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний сүүлийн 5 жилийн байдалд судалгаагаар:</p> <ul style="list-style-type: none"> - Гэдэсний халдварт өвчний 75% гэр хороололд бүртгэгдсэн. - Ундны усны эх үүсвэрийн худгийн усанд иодын дундаж агууламж 0.12±0.007 мг/л, ундны усны стандартын шаардлага хангасан. Гэвч сүүлийн 5 жилд иод хомсдолтой хамааралтай бамбайн өвчнүүд 10.000 хүн амд 3,6 тохиолдлоос 24,1 тохиолдол хүрч өссөн байдлыг хүн амын дундах иод агуулсан хүнс, давсны хэрэглээтэй уялдуулан судлах, бага насны хүүхдийг иод дутлаас сэргийлэх шаардлага байгааг харуулж байна. - Ундны ус зөөвөрлөх болон хадгалах савны хэрэглээнд зориулалтын канестрийг 62,5% нь ашигладаг, 60% нь өдрийн хэрэглээндээ 20 хүртэл литр усыг хэрэглэдэг байна. <p>Орчны эрүүл мэндийн чиглэлээр 84 эмч, эмнэлгийн мэргэжилтэнийг чадавхжуулах сургалтад хамруулсан.</p>	100	
10	Орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд	Үйл ажиллагааны	-	85%аас дээш	<p>Дэлхийн орчин болон усны өдрийн хүрээнд мэргэжлийн 7 байгууллагатай хамтран 13 төрлийн арга хэмжээг зохион</p>	100	

		үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	тайлан			байгуулснаас эрүүл мэндийн салбарын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан салбаруудад хүргүүлж, хэрэгжилтийг 92% ханган ажиллалаа. Үүнд: - “Ундны усны эрүүл ахуй” сэдэвт цахим сургалтад Багийн нийгмийн ажилтан 25 хүнийг хамруулсан. - “Ногоон ариусал” ХХК-тай хамтран “Газрын доорх ус-үл харагдах усыг таниульа” АХА тэмцээнд Орхон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 40 сурагчийг хамруулж, эхний 3 байрыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. - “Ундны усны савны эрүүл ахуй”, “Нүхэн жорлонгийн стандарт” гарын авлага тус бүр 200 ширхгийг БОАЖГ-ын санхүүжилтээр хэвлүүлж, түгээсэн. Орон нутгийн хэвлэлээр 2 удаа мэдээлэл өгч, 3 удаагийн нээлттэй хаалганы өдрөөр 300 гаруй иргэнд зөвлөгөө өгч ажилласан. Ус хөрс, агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх 3 төрлийн гарын авлага, 11 төрлийн мэдээллийг 17549 хүнд хүргэсэн.	
11	Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах		Үйл ажиллагааны тайлан	85%	85%-аас дээш	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын гадаад тээвэрлэлт, устгалын үйл ажиллагааг бүх шатны эрүүл мэндийн байгууллага “Ногоон ариусал” ХХК-тай гэрээгээр гүйцэтгүүлсэн. Хог хаягдлын менежментийг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх салбар хоорондын уулзалтыг 2 удаа хийж, 3 асуудал шийдвэрлэсэн. Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр удирдамжтай 2 удаагийн хяналтыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хийж, зөвлөмжөөр хангасан ба зөвлөмжийн хэрэгжилт 88,5%-тай байна. “Ногоон ариусал” ХХК-ын үйл ажиллагаанд хяналт хийж, зөрчил, дутагдлыг удирдлагуудад танилцуулан, зөвлөмж хугацаат үүрэг даалгаврыг албан тоотоор хүргүүлэн хамтран ажилласнаар хогийн нэгдсэн цэгт 2га газарт устгалын талбайг тохижуулсан. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент” сургалтад хамрагдсан 2 мэргэжилтэн эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдал хариуцсан 30 ажилтанд сургалт хийж чадавхжуулсан. Тайлант хугацаанд химийн	100

						болон эмийн хугацаа дууссан 1333 кг хог хаягдлыг худалдан авсан байгууллагуудад гэрээний дагуу буцаан нийлүүлж ажилласан. Ногоон ариусгал ХХК нь гэрээний дагуу 32,5 тн эмнэлгийн халдвартай хог хаягдлыг устгасан нь өнгөрсөн оны мөн үеэс 1,5 дахин буурсан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 88,5%-тай байна	
Зорилт 4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ	12	Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх	Хариу арга хэмжээний чадавхын хувь	85%	86%	ЭМГ-ын даргын А/09 дүгээр тушаалаар гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн албаны эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөнд бие бүрэлдэхүүн, хүч хэрэгсэл, нөөцийг тодотгосон. Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын бэлтгэл ажлын хүрээнд жагсаалын үзлэг 6 удаа, танхимын сургалт 5 удаа, хээрийн эмнэлгийн зураглалын дагуу хээрийн эмнэлэг дэлгэх үзүүлэх сургуулилт хийж бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхэд 95%-тай, гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтаар онц үнэлгээгээр дүгнэгдсэн. ЭМЯ, ХӨСҮТ-тэй хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтэн 120 хүнийг 2 удаагийн сургалтад хамруулсан. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 95% болж өмнөх оноос 10%-аар нэмэгдсэн.	100
	13	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх	Нөөц бүрдүүлэлтийн хувь	80%	85%	Эрүүл мэндийн гамшгийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг нэмэгдүүлсэн. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 нэр төрлийн 289,5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис байна. 2022 оны байдлаар Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн байна. КОВИД-19-ын ПГУ болон түргэвчилсэн оношлуурыг Эрүүл мэндийн газрын даргын	100

						тушаалуудаар Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд хуваарилан нөөц бүрдүүлэлт 3-4 сарын нөөцтэй болж лабораторийн чадавх өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,5%-аар нэмэгдэж 88,5% болсон байна. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт 85%-тай байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 95,5%, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-тай байна.	
Зорилт 5. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.	14	Халдварт өвчний тохиолдол бүрт тандалт судалгаа хийх, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах чиглэлээр холбогдох салбарын байгууллагуудтай хамтран ажиллах	Үйл ажиллагааны тайлан Хэрэгжилтийн хувь	90%	92%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд Халдварт өвчний 4672 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 449,3 промилл ногдож, өмнөх оноос (669.1)-промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 87,1%-ийг амьсгалын замын халдварт өвчин, 3,2%-ийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 1,4%-ийг гэдэсний халдварт өвчин, 8,3%-ийг бусад халдварт өвчин тус тус эзэлж байна. Дархлаажуулалтын хамралт 98,7%-тай байна. <u>Тархвар судлалын заалтаар Хачигт энцефалитын</u> вакцинд 250, гепатит В вирусийн эсрэг вакцинд 735 хүн хамрагдсан. Дархлаажуулалт бүхий халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол, дархлаажуулалтын дараах хүндрэл бүртгэгдээгүй. Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3-р тунгийн хамралт 57,6% буюу өмнөх оноос 1,9 хувиар нэмэгдсэн 5-11 насны Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг "Комернэти"/BNT162b2/ вакцин 256 хүүхэд хамруулсан. Улирлын томуугийн эсрэг дөрвөн цэнт вакцинд 12477/90,7%/ иргэн сайн дураар хамрагдсан. Сүрьеэгийн үзлэгт нийт 8859 хүн хамруулснаас 87,5% нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байна. Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 51 бүртгэгдэж, 10000 хүн амд 4,8 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3,9 промиллоор нэмэгдсэн байна. Бэлгийн замаар дамжих халдварын 154 тохиолдол бүртгэгдэж нийт халдварт өвчний 3,2%-ийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,7%-аар, 10 000 хүн амд 14,5 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 6,3 промиллоор тус тус	100

					нэмэгдсэн байна. Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь 92,7%-тай өмнөх оноос 2.7% өссөн байна.	
15	Заавал хийх товллын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалтыг зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, тарилгатай халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тандалтыг эрчимжүүлэх	Дархлаажуулалтын хамралт 99,5%-иас бууруулахгүй байна.	99,1	99,1%-аас бууруул ахгүй байна.	Тайлант дархлаажуулалтад хамрагдвал зохих 12306 хүүхдээс 12152 хүүхэд хамрагдаж, хамралт 98,7% байна. Товлолын дархлаажуулалтын хамралтыг сүүлийн 3 жилээр дүгнэн, цаашид авах арга хэмжээг төлөвлөсөн. Цар тахлын 2 жилд дархлаажуулалтаас хоцорсон 354 хүүхдийг нөхөн дархлаажуулалтад хамруулсан. Товлолын дархлаажуулалтын 10 цэгт удирдамжит хяналт 3 удаа хийн, зөвлөмж өгч ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 95,5%-тай байна. Мэргэжлийн хяналтын газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, товллын дархлаажуулалтын цэгүүдийг эрүүл зүйн лабораторийн шинжилгээнд 100% хамруулсан. Орон нутагт вакцины зориулалтын агуулах, барих саналыг хүргүүлж, газрын зөвшөөрөл гарч, төсвийн төсөл хийгдсэн. Дархлаажуулалтын чиглэлээр чадавхжуулах 2 удаагийн сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн төвийн давхардсан тоогоор 48 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Дархлаажуулалтын мэргэшүүлэх сургалтад хамрагдах судалгааг гарган, 4 сувилагчийг вакциначторын мэргэшүүлэх сургалтад хамруулсан. Хачигт энцефалитын вакцинд 250, гепатит В вирусийн эсрэг вакцинд 735 хүн хамрагдсан. Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3-р тунд 37645/57,9%/, 4-р тунд өссөн дүнгээр 5490/15,5%/ иргэн хамрагдсан. 5-11 насны хүүхдийг Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг 256 хүүхэд хамрагдсан. Улирлын томуугийн эсрэг дөрвөн цэнт вакцинныг 13750 хүн тун татан авч, 12701/92,4%/ иргэн сайн дураар хамрагдсан. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.	90
16	Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, хариу арга хэмжээний чадавхыг	Үйл ажиллагааны тайлан	84%	85%	Зоонозын халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг 3 чиглэлээр батлан хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний хэрэгжилт 92%-тай байна. “Нэг эрүүл мэнд” салбар зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, хамтарсан сургалт 2 удаа, өдөрлөг 1 хийж, 106	100

		сайжруулах, салбарын байгууллагуудтай хамтран ажиллах				хүн хамрагдсан. Мөн малын боом өвчний 1 тохиолдлын голомтын хариу арга хэмжээг авч ажилласан. Хачигт энцефалитын эсрэг вакциныг 800 хүн тун татан авч, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр сайн дураар үнэ төлбөргүйгээр 250 иргэнийг хамруулсан. Хачигт халдварын сэжигтэй 48 тохиолдолд тандалт хийн, 10 тохиолдлын сорьцыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвд хүргүүлж, шинжлүүлэхэд 1 тохиолдол батлагдсан. Хачигт халдвараас сэргийлэх зөвлөмж, хачигт энцефалитын эсрэг вакцинд сайн дураар хамрагдах мэдээлэл орон нутгийн 6 телевизэд өгсөн. Тайлант хугацаанд бруцеллөз 1 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 34 тохиолдлоор, 10,000 хүн амд 3,2 промиллоор буурсан. Бруцеллөз өвчний мэдлэг хандлагыг үнэлэх асуумж судалгааг сургалтад оролцогсдоос авч дүгнэхэд: мэдлэг 49%, хадлага 40,7%, эрсдэл 60% байна. Тарваган тахал өвчний урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээг эрчимжүүлэх хүрээнд Цагдаагийн газартай хамтран орон нутгийн орох, гарах хяналтын цэгт иргэдэд чиглэсэн 2 төрлийн зурагт хуудас, сэрэмжлүүлэг байрлуулан, орох гарах цэгийн хяналтыг тавьж ажиллалаа. Орон нутгийн 1 телевизээр иргэдэд зориулсан сэрэмжлүүлэг мэдээллийг Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран иргэдэд хүргэсэн. Орон нутгийн 4 сайт, эрүүл мэндийн салбарын 12 байгууллагын цахим хуудаст 4 төрлийн сэрэмжлүүлэг, зөвлөмж байршуулж, 26450 хүнд хүргэсэн.	
17	Халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэн ажиллах	Хэрэгжилтийн хувь Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар	82% 0	85% 0	Эрүүл мэндийн байгууллагуудад халдварын сэргийлэлт, хяналтын баг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажилласан. Халдварын сэргийлэлт хяналтын салбар зөвлөлийн 2022 оны 13 заалт бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт 90,7% байна. Мэргэжлийн хяналтын газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, эрсдэл өндөр 34 байгууллагуудад эрүүл зүйн шинжилгээ хийхэд эмгэг төрөгч илрээгүй байна. Эрүүл мэндийн байгууллагуудын төрөл, үзүүлж буй тусламж үйлчилгээ чиглэлээс хамааран хуваарийн дагуу дэмжлэгт хяналтыг	100	

						2 удаа хийж, зөвлөмж өгч ажилласан. “Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлье” сарын аян зохион байгуулж, 5 чиглэлээр 25 арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэгийг сорих тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж, 52 багийн 260 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулснаас Энхжихмандирваа, Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвүүд тэргүүлсэн бол аяны хүрээнд дотооддоо зохион байгуулсан ажлын үнэлгээгээр Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв шалгарсан. Эмч эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах сургалтыг 3 удаа зохион байгуулж, 135 эмч, эмнэлгийн ажилтан, ажлын байран дахь дадлага сургалтад 23 сувилагч хамруулан чадавхжуулсан.	
--	--	--	--	--	--	--	--

2. Ерөнхий чиг үүрэг: Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Үндсэн чиг үүрэг: Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагуудад оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.	18	Өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллах	Хэрэгжилтийн хувь	88,2%	89%	Аймгийн Засаг даргын 2022 оны А/104 дүгээр захирамжаар байгуулагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсэг 2 удаа дүгнэсэн. 2022 оны жилийн эцсээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бүлгээр 90,1%, төвийн удирдлага, манлайллын бүлгээр 90,6%, нэгдсэн үнэлгээгээр 90.2%-аар үнэлэгдсэн.	100
	19	Сум, өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх анхан шатлалын тусламж үйлчилгээнд шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, лабораторийн оношилгоо, өдрийн, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийг бэхжүүлэх	Эрүүл мэндийн даатгалаар тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	8410	Нэмэгдсэн байна	Тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын дөрвөн багц үйлчилгээгээр сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр 930 иргэн гэрийн тусламж үйлчилгээ, 1568 иргэн өдрийн эмчилгээ, 2604 иргэн сэргээн засах тусламж үйлчилгээ, 6909 иргэн оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээ, нийт 12011 иргэн тусламж үйлчилгээ авч 380,9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.	100
	20	БОЭТ-ийн оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх	Шинэ дэвшилтэт технологи	3	3	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд бүс нутгийн хэмжээнд доорх тусламж үйлчилгээг үзүүлэн сурталчлан ажиллалаа. Үүнд:	100

		чадавхыг нэмэгдүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн шинэ дэвшилтэт технологийг нутагшуулах	нэвтрүүлсэн тоо			<ul style="list-style-type: none"> - Ангиографийн аппарат тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж <u>Шастины нэрэмжит 3-р төв эмнэлгийн ангиографийн эмч нарын баг бүрэлдэхүүний хамт эмчилгээ, оношилгооны чиглэлээр гардан сургалтуудыг зохион байгуулж цаашид хамтран ажиллах гэрээ байгуулсан. Нийт 217 хүнд оношилгоо, эмчилгээг хийсэн байна.</u> - Сэргээн засах тусламж үйлчилгээнд 18 нэр төрлийн 150 сая төгрөгийн тоног төхөөрөмж орон нутгаас нийлүүлэгдэж <u>Ковидын дараах сэргээн засах кабинетыг шинээр нээн ажиллуулж харьяаллын болон бүс нутгийн хэмжээнд 550 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.</u> - Нүдний кабинетэд дутуу нярайн нүдний гажгийг илрүүлэх шинжилгээг бүс нутгийн хэмжээнд үзүүлж нүдний нийгэмлэгээр дамжуулан бусад аймгуудад сурталчлан ажилласан. - Оношилгоонд ургийн хяналтын монитор, ургийн доплер аппаратыг нэвтрүүлж, ургийн цусан хангамж, төрөлхийн зүрхний гажгийг эрт үед нь илрүүлж байна - Эрэгтэйчүүдийн <u>урологийн үзлэг, оношилгоо, хагалгааг</u> бүс нутгийн хэмжээнд үзүүлж, тайлант хугацаанд 58 мэс засал хийгдсэн. <p>Шинжилгээний хариу хэвлэх <u>киоски</u> машиныг байрлуулж, E Mongolia цахим системд бүс нутгийн иргэдийн цаг авах, шинжилгээний хариу авах үйлчилгээг нэвтрүүлсэн.</p>	
21	Эмнэлгийн яаралтай тусламжийг хугацаа алдалгүй үзүүлэх, яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Яаралтай дуудлагад 20 минутын дотор очсон хувь	95%	95%	<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Яаралтай тусламжийн хүлээн авах тасагт Жайка олон улсын хамтын ажиллагааны төслөөс 120 сая төгрөгийн 4D ЭХО аппарат, амилуулах өрөөнд суурин амьсгалын аппарат шинээр суурилуулсан. Ажиглах хяналтын хэсэгт телемедицины дэлгэцийг дагалдах тоног төхөөрөмжийн хамт байрлуулан лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй шууд холбогдож 30 иргэнд зөвлөгөө авсан. Шархны анхны цэгцлэлт хийх мэс заслын өрөөнд туяагаар гар ариутгагч, оёдлын иж бүрдэл 3 ширхгээр хангаснаар эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас сэргийлсэн. Яаралтай тусламжийн хүлээн авах тасгийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85% болж өмнөх оны</p>	100	

						<p>мөн үеэс 5%-аар нэмэгдэж, яаралтай тусламж үзүүлэх чадавх 90%-д хүрсэн. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамнаас түргэн тусламжийн тасгийг тоноглол бүхий 1 автомашинаар хангаснаар 13 түргэн тусламжийн машин дуудлагад үйлчилж ажилласан.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламж үзүүлэх нэгжийг шинээр байгуулж амилуулах суурь тусламжийг үзүүлэх багийг томилон гардан үйлдлийн сургалтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран 2 удаа зохион байгуулж чадавхжуулсан. Тус нэгжүүдэд хяналтын монитор 8, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 10, отсос 8, дефибрилятор 5 ширхгийг байрлуулсан ба хүчилтөрөгчийн гуурс нэг сарын нөөцтэй, амин чухал эм, тариа 1-2 сарын нөөцтэй байна. Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Жаргалант сумын эрүүл мэндийн төвд төрөх болон яаралтай тусламжийн иж бүрдлийн цүнхээр хангагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 95%, гардан үйлдлийн чадавх 89%-тай байна. Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт эрчимт эмчилгээний тасгийг нээн ажиллуулж багаж тоног төхөөрөмжөөр 100% хангасан. Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн яаралтай тусламжийн нэгжийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85%, гардан үзүүлэх чадавх 82%-тай байна. Тайлант хугацаанд 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 500 гаруй сурагч, 60 гаруй сургууль цэцэрлэгийн багш ажилтныг амилуулах суурь тусламжийн сургалтад хамруулсан. Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран “Яаралтай тусламжийн үеийн үнэлгээ болон авах арга хэмжээ” сургалтыг зохион байгуулж 150 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх 95% байна.</p>	
22	Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн хувь	80,8%	82%	<p>Уламжлалт анагаах ухааны хүний нөөцийн хангалт 75 хувьтай болж 3%-аар нэмэгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сэргээн засах тусламж үйлчилгээний тасагт их эмч 2, бага эмч 2, хөдөлгөөн засалч 3, хөдөлмөр засалч 1, сувилагч 4, 	100	

						<p>Уламжлалт, хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасагт их эмч 2, бага эмч 1, сувилагч 3 хүний орон тоотой тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд уламжлалтын эмч тус бүр 1, бага эмч 3, сэргээн засахын сувилагч 2, бариа заслын сувилагч 2 ажилласан. - Хувийн хэвшлийн 16 эрүүл мэндийн байгууллагад уламжлалт анагаах ухааны 39 эмч, бага эмч сувилагч 36, нийт 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тусламж үйлчилгээг үзүүлсэн. <p>Тайлант хугацаанд уламжлалт эмчилгээний 7 төрлийн 20 зөөлөн болон ширүүн засал, 30 гаруй нэр төрлийн танг эмчилгээндээ ашиглаж, 6854 хүнд амбулаторийн үзлэг хийж өдрийн эмчилгээнд хамруулсан ба 3456 үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчилж, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Нийт 7413 иргэнийг сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулсан байна.</p> <p>Тайлант хугацаанд уламжлалт анагаах ухааны ороолт засал, дэвтээлгэ засал нэмэгдсэнээр уламжлалт анагаах ухааны нэр төрөл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,5%-аар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Үйл ажиллагааны хэрэгжилт 85%-тай байна.</p>	
23	Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, эмнэлгийн тохиолдлыг бууруулах	Хэрэгжилтийн хувь	75%	80-85%	<p>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой 13 клиникт чанарын баг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Эрдэнэт сувилалд орон тооны бус чанарын алба ажилласан. Тайлант жилийг “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах жил” болгон зарласантай холбоотой ЭМГ-ын даргын 2022 оны А/39 дүгээр тушаалаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй сайжруулах 2022-2025 оны төлөвлөгөөг батлан эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага болон чанарын алба, багийн дарга нарт сургалт зохион байгуулж чадавхжуулсан.</p> <p>Эрүүл мэндийн хөгжлийн төвийн чанар, магадлан итгэмжлэлийн албатай хамтран чанарын алба, багийн дарга 50 хүнийг, Эрүүл мэндийн газраас эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд болон чанарын алба, багийн</p>	100	

					<p>дарга нарыг чадавхжуулах сургалтад 40 хүнийг тус тус хамрууллаа.</p> <p>Эмчилгээний хоолны чанарыг сайруулах, уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2 зөвөлгөөн зохион байгуулж 160 гаруй эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Магадлан итгэмжлэл сунгуулах 6 байгууллага, шинээр орох 3 байгууллагын чанарын багийн үйл ажиллагаанд хяналт хийж мэргэжил арга зүйн ханган ажилласан. Эрүүл мэндийн 6 байгууллагад хөндлөнгийн явцын хяналт, 12 байгууллагад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөнд хяналт шинжилгээ хийхэд хэрэгжилт 95%-тай байна.</p>	
24	Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	75%	90%	<p>Орон нутагт анх удаа эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн чиглэлээр сувилахуйн мэргэшүүлэх сургалт зохион байгуулах эрхийг авч аймгийн хэмжээнд 12 сувилагчийг сургагч багшаар бэлтгэсэн. Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор АШУҮИС-тай хамтран зохион байгуулсан судалгааны арга зүйн чадавхжуулах сургалтад 68 эмч, сувилагчийг хамруулсан.</p> <p>Эрдэм шинжилгээний бага хуралд I, II шатанд хэлэлцэгдсэн 48 судалгааны илтгэлээс 8 илтгэлийг шалгаруулж 3,2 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Тус хурал нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр олон асуудал дэвшүүлсэн, цар тахлын үеийн эмчилгээ, оношилгоо, урьдчилан сэргийлэлт, бэлэн байдал, хариу хэмжээг дүгнэсэн, сургамж үлдээсэн онцлогтой хурал байсан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2022 А/647 тоот захирамжаар орон нутгаас 20,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн “Байнгын асаргаа сувилгаа шаардлагатай иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлье” уриан дор сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байнгын асаргаа сувилгаа шаардлагатай 116 иргэнд олон мэргэжлийн багаас бүрдсэн нийт 46 эмч, сувилагч гэрийн асаргаа, сувилгааны тусламж үйлчилгээг үзүүлсэн. Байнгын</p>	100

						асаргаатай иргэдийн 118 асран хамгаалагч нарыг сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хөнгөвчлөх эмчилгээний тасагт 588 үйлчлүүлэгч 4022 ор хоног хэвтэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөвчлөх шалтгааны улмаас эмнэлэгт хэвтэлт 1448 тохиолдлоор нэмэгдсэн бөгөөд харьяаллын бус 14 хүн эмчлүүлсэн байна. Хорт хавдрын шалтгааны улмаас хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 20.3%-ийг хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл, 8.4 хувийг амьсгалын замын эрхтэн тогтолцоо, 7.2%-ийг шээс бэлэгсийн эрхтэн тогтолцооны өвчлөл эзэлж байна. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн 202 үйлчлүүлэгчид ZOOM болон Video call ашиглан биеийн байдлыг тандан асаргаа сувилгааг зөвлөж, тусламж үйлчилгээ үзүүлсэн. “Элбэрэлт энэрэхүй орчлон” ТТБ-тай хамтран хорт хавдрын 3,4-р үе хожуу шатандаа оношлогдож хөнгөвчлөх эмчилгээнд шилжсэн 46 иргэнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг гэрээр үзүүлсэн. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний бусад нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд сарниулах эмчилгээний төрлүүд болох зураг эмчилгээ, тоглоом эмчилгээ, хөгжим эмчилгээг давхардсан тоогоор 412 хүнд 24 удаагийн давтамжтай биечлэн болон цахимаар хүргэж ажилласан. Мөн “Бүлгийн ярилцлага ба хамтдаа дуулья” сэдэвт сарниулах 4 удаагийн эмчилгээнд 123 хүн хамрагдсан. Тайлант хугацаанд 952 хүнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.	
Зорилт 2. Эх, хүүхэд, зорилтот бүлгийн хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	25	Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, тусламж үйлчилгээнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах	Эх хүүхдийн тусламж үйлчилгээний үзүүлэлт /промиллоор/	-Эхийн эндэгдэл -0 -Нялхсын эндэгдэл -8,3 -5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	-Эхийн эндэгдэл-0 -Нялхсын эндэгдэл-8,0 -5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-	“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 85% байна. Тайлант хугацаанд: Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар салбаруудад мэдээлэл 5, 5 удаагийн хяналт хийж, зөвлөмж 3 удаа хүргүүлж ажилласан. Орон нутгийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Эх хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” 3 сарын болзолт уралдааныг зохион байгуулж, 3 өрхийн эрүүл	100

				-10.2	10.0	<p>мэндийн төвийг шалгаруулж, урамшуулсан.</p> <p>Орон нутгаас төсөв шийдвэрлэж амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд сурфактант эмчилгээг хийж, 86,6 хувийн үр дүн өгсөн байна.</p> <p>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2,0 сая төгрөгийн төсвөөр зорилтот бүлгийн 100 хүүхдийг аминдэмжүүлсэн.</p> <p>"Зүрх мартаггүй" төслийн хүрээнд зүрхний төрөлхийн гажигтай 0-16 насны 152 хүүхдийг үзлэгт хамруулж, 45 хүүхдийг хагалгаанд оруулахаар 13,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.</p> <p>Давхардсан тоогоор сум, өрхийн 112, хүүхдийн байгууллагын 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, баг, сургуулийн нийгмийн ажилтан, цагдаагийн 141 ажилтныг мэдээлэл, зөвлөмжөөр хангасан.</p> <p>Томуу томуу төст өвчин алаг цоог дэгдэлтийн түвшинд хүрсэн тул нэмэлтээр 200-250 ор дэлгэж, гэрийн эргэлт, уртасгасан цагийн зохицуулалт хийж, өрх, хувийн хэвшлийн 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулсан.</p> <p>ЭМГ-ын дэргэдэх Магадлан хэлэлцэх зөвлөлөөс сургалт хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, 21 багийн хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулсан.</p> <p>16-49 насны эмэгтэйчүүдийн 62,1 хувь гэр бүл төлөвлөлтийн 5 төрлийн арга хэрэгсэлд хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар нэмэгдсэн.</p> <p>Төрөлт 2287 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,2%-аар буурсан. Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 6,6 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,8 промиллоор, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 промиллоор тус тус буурсан байна.</p>	
26	Хүүхэд өсвөр үеийн болон нөхөн үржихүйн туламж үйлчилгээний чанар хүртээмжийг	Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны		17,2%	18%	"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, шалгуурыг батлуулсан. Жирэмсний хяналт, эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар салбаруудад	100

		нэмэгдүүлэх	эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулсан хувь		<p>мэдээлэл 5, зөвлөмж 1 удаа хүргүүлэн хяналт тавьж ажилласан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувьтай байна. Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Эх хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв" 3 сарын болзолт уралдааныг зохион байгуулж, 3 өрхийн эрүүл мэндийн төвийг шалгаруулж, урамшуулсан. - Орон нутгаас төсөв шийдвэрлэж амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 15 нярайд сурфактант эмчилгээг хийж, 86,6 хувийн үр дүн өгсөн байна. - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2,0 сая төгрөгийн төсвөөр зорилтот бүлгийн 100 хүүхдийг аминдэмжүүлсэн. - "Зүрх мартахгүй" төслийн хүрээнд зүрхний төрөлхийн гажигтай 0-16 насны 152 хүүхдийг үзлэгт хамруулж, 45 хүүхдийг хагалгаанд оруулахаар 13,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. - Эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт тайлант хугацаанд 0-5 насанд 7540 буюу 61,5%, 6-17 насанд 6283 буюу лавлагаа шатлалын эмнэлэгт 1203 хүүхдийг илгээсэн. - Давхардсан тоогоор сум, өрхийн 112, хүүхдийн байгууллагын 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, баг, сургуулийн нийгмийн ажилтан, цагдаагийн 141 ажилтныг мэдээлэл, зөвлөмжөөр хангаж хүүхэд хамгааллын багийг чадавхжуулсан. - Томуу томуу төст өвчин алаг цоог дэгдэлтийн түвшинд хүрсэн тул нэмэлтээр 200-250 ор дэлгэж, гэрийн эргэлт, уртасгасан цагийн зохицуулалт хийж, өрх, хувийн хэвшлийн 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг нэмэлтээр ажиллуулсан. - Тус хугацаанд төрөлт 1901 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10%-аар буурсан. Нялхсын эндэгдлийн 8 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 4,2 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8,4 промиллоор, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн 9 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 4.7 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.8 промиллоор тус тус буурсан эерэг 	
--	--	-------------	---------------------------------------	--	---	--

						<p>үзүүлэлттэй байна.</p> <p>- 16-49 насны эмэгтэйчүүдийн 62,1 хувь гэр бүл төлөвлөлтийн 5 төрлийн арга хэрэгсэлд хамрагдаж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>Өсвөр үе, зорилтот бүлгийн 546 эмэгтэйг нөхөн үржихүйн насны 4640 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтад хамруулсан нь нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйн 18,5%-ийг эзэлж зорилтот түвшинд хүрсэн.</p>	
Зорилт 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хяналтыг сайжруулна.	27	Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, тогтвортой үйл ажиллагааг хангах, хяналтыг сайжруулах	ЭХНБ, эмийн сангуудын стандартын хэрэгжилт	88,1%	90%	<p>Тайлант хугацаанд нийтийн үйлчилгээтэй 81 эмийн сан, 13 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллага шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан.</p> <p>49 эмийн санд “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд дунджаар 90,1% үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,4%-аар сайжирсан байна. “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих шаардлага MNS5530:2014 стандарт”-аар 6 байгууллагад хяналт хийхэд дунджаар 93,4% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 5,3%-аар сайжирсан байна. Зөвлөмжийг эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудад хүргүүлж, хяналт тавин ажилласан.</p>	100
	28	Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	82%	<p>Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 110 эм зүйч, 136 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 10,1%, эм найруулагч 19,5 хувиар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 9 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50%-аар нэмэгдсэн.</p> <p>Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 55-65%-д тарилгыг хийж, 21-45%-д уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 4,5%-аар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 1-5%-аар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилт 82,0% болж 0,5%-аар</p>	80

						нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээний алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,7%-аар буурсан байна. Эмнэл зүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 81,6%-тай байна.	
3.Ерөнхий чиг үүрэг: Хүний нөөцийн хөгжлийн стратеги							
Үндсэн чиг үүрэг: Эрүүл мэндийн ажилтны урт чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг сайжруулна.							
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох	29	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2021-2025 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	85,8%	86%	Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт нийт 1830 эмч эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаагаас 390 их эмч, 433 сувилагч, эм зүйч 131, эх баригч 28, бага эмч 88 ажилласан. Төлөвлөлтөөр хүний нөөцийн хангалт 85 хувь хэрэгжилттэй байна. Байгууллагын <u>вэб</u> сайтын ил тод цэсэд хүний нөөцийн ил тод байдал хэсэгт ажлын байрны талаарх мэдээлэл, сул ажлын байрны зар болон хүний нөөцийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг хангах чиглэлээр гарсан тушаал шийдвэр, дүрэм, журмыг байршуулан, тухай бүр шинэчлэн ил тод байдлыг ханган ажиллалаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд эрүүл мэндийн салбарт 50 эрүүл мэндийн ажилтныг ажлын байраар хангасан. Хөгжлийн бэрхшээлтэй 22 иргэнийг ажлын байраар ханган ажиллуулж байна. Эрүүл мэндийн ажилтны сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах зорилго бүхий аймгийн “Эмч” хөтөлбөрийн хэрэгжилт 96%-тай байна. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт 85,95%-тай байна.	75
	30	Төлөвлөлтийн дагуу төгсөлтийн дараах сургалтад эмч, сувилагчдыг үндсэн болон төрөлжсөн мэргэшлээр сургах, мэргэшүүлэх	Эмч, эмнэлгийн мэргэжилтний хамрагдсан хувь	27	28	Тайлант хугацаанд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад 79 эмч, 91 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн, нийт 170 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна. Нэн шаардлагатай хүүхдийн мэс засал, компьютер томограф соронзон давтамжит дүрс оношилгоо судлалаар улсын төсвийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2 эмчийг сургалтад хамруулсан. БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 резидент эмч суралцаж байгаа ба “Эрчимт эмчилгээний сувилахуй”, Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтыг 2022 оны 10 сарын 01-ээс эхлүүлж 16 сувилагч элсэн суралцаж байна. Докторын зэрэгтэй	100

						эмч 0,2%, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 12%-тай байна. Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12.9% нь хамрагдсан байна.	
Зорилт 2. Эрүүл мэндийн ажилтны үр чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх	31	Танхимын болон зайн сургалтад хамрагдах эмч эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх	Хамрагдсан хувь	50%	52%	Тайлант хугацаанд нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 74,4% ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдаж, Төвийн болон орон нутагт зохион байгуулсан ажлын байран дээр дадлагажуулах 4 удаагийн сургалтад 100 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.	100
	32	Эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургах, лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг БОЭТ, төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон анхан шатлалд сэлгэн ажиллуулах арга хэмжээг авах	Эмч эмнэлгийн мэргэжилтний ажлын байр сэлгүүлэн ажиллуулсан тоо	21	21	Тайлант хугацаанд 71 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна. Үүнд: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас нийт 62 эмч, сувилагчийг ажлын байранд сэлгэн ажиллуулсан. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн инженерийг хувийн хэвшлийн эмнэлгүүдэд болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гэрээгээр ажиллаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж үйлчилсэн. - Хувийн хэвшлийн ор бүхий 10 клиник 8 эмч зүйчийг гэрээгээр сэлгэн ажиллуулж байна. Дадлагажуулах 4 удаагийн сургалтад 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Үүнд: - Улаанбаатар хотын Интерсайнс ХХК-аас лабораторийн тоног төхөөрөмж, шинжилгээ авах, хяналтын тест тавих сургалтад 35 эмч, эмнэлгийн мэргэжилтэн - Цахимаар МЮКЭС-ээс гадаад хяналт, биохими, цусны дэлгэрэнгүй, тохиргоо үзэх сургалтыг лабораторийн нэгдсэн тасгийн эмч, лаборант нарт - БОЭТ-ийн лабораторийн нэгдсэн тасгаас хүлээх авах 5 тасгийн 20 эмч, сувилагч нарт БОЭТ-ийн лабораторийн нэгдсэн тасгаас түргэвчилсэн тест авах арга зүйн сургалтад 35 эмч, сувилагчид тус тус зохион байгуулсан байна.	100
	33	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийг	Мэргэжлийн зэрэг ахиулсан эмч,	23%	24%	2022 онд нийт 21 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг шинээр хамгаалснаас зөвлөх зэрэг 1, тэргүүлэх зэрэг 8, ахлах зэрэг 12 эмч, эмнэлгийн	100

		жил бүр ахиулах	эмнэлгийн мэргэжилтний тоо			мэргэжилтэн хамгаалсан нь өмнөх оноос 28,8%-аар нэмэгдэж 26,7%-ийг эзэлж байна.	
Зорилт 3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ	34	“Эмч” дэд хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	90%	92%	<p>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор “Эмч” хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаж орон нутгаас 60,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Хөтөлбөрийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гамшиг нийгмийн цаг үеийн байдалтай холбоотой дотоод сургалтад 1031 эмч, ажилтныг хамруулсан. - Австри улсын <u>Зайлибург</u> хотод сургалтад 1 эмч, Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 3 сувилагчийг хамруулсан. - Дэлхийн эмч нар болон олон улсын сувилагчдын өдрийн хүрээнд Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж шилдэг 12 илтгэлийг шалгаруулсан. Судалгааны арга зүйн сургалтад 68 эмч, сувилагчийг хамруулсан. Эмч, сувилагчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, алдаршуулах хүрээнд ажил мэргэжлийн уралдаан 1, хэлэлцүүлэг 1, <u>теле</u> нэвтрүүлэг 4, аян 2 удаа зохион байгуулж, шилдэг 3 байгууллагыг шалгаруулсан. - Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн болон эрүүл мэндийн салбаруудын удирдлага 70 гаруй хүний төлөөлөл оролцлоо. - Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 80 жилийн ой хүрээнд багш шавийн уулзалтыг <u>зохион</u> байгуулж, 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 резидент эмч, төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 16 сувилагч элсэн суралцсан. - Англи хэлний чадварыг дээшлүүлэх сургалтад 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тайлант хугацаанд 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1024, багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Тайлант хугацаанд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд 	100

					<p>гомдол ирээгүй.</p> <p>- 40-ээс дээш насны 329 эрүүл мэндийн ажилтанд хавдрын маркер тодорхойлж, 3 мэргэжилтнийг нарийн мэргэжлийн эмчид илгээсэн.</p> <p>Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12.9% нь, нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 17% нь хамрагдсан байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилт 96%-тай байна.</p>	
35	<p>Эрүүл мэндийн байгууллага бүр эмч, эмнэлгийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, хяналтад авах, эмчлэн эрүүлжүүлэх</p>	<p>Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны хувь</p>	75%	95%	<p>Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Эрүүл мэндийн газрын 687 ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт насны ангиллаар орж байгаагаас 92% нь хамрагдсан.</p> <p>“Эмч” хөтөлбөрийн хүрээнд 10 сая төгрөгийн санхүүжилтээр Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 40-өөс дээш насны 330 ажилтныг хавдрын маркерын шинжилгээнд хамруулснаас 3 ажилтан өөрчлөлттэй гарсныг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээсэн. Эрүүл мэндийн бүх ажилтнуудыг халдвараас сэргийлэх, тэдний дархлааг дэмжих зорилгоор хүрээнд томуугийн сайн дурын дархлаажуулалтад 115 эмч эмнэлгийн ажилчдыг хамруулж 512 ажилтанд витамин С 1000 мг, витамин Д 2000 ед нэг сарын хэрэглээгээр хангасан. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг 100% дархлааг дэмжих аминдэм, халуун хоол, халуун аарц, чацаргана, амны хаалт зэргээр хангасан.</p>	85
36	<p>Эрүүл мэндийн байгууллага бүр ослыг тэглэх осол мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх.</p>	<p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь</p>	-	75%	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 25 сэдвээр сурталчилгааг цахим сүлжээнд байршуулж, сурталчилсан.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Эрүүл мэндийн газрын 687 ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт насны ангиллаар орж байгаагаас 92% нь хамрагдсан. Мэргэжлээс шалтгаалах өвчний асуудал эрхэлсэн төв байгууллагад илгээж онош тодруулах шаардлагатай ажилтан байхгүй байна. Эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн хэвийн бус хортой нөхцөлд ажиллаж буй 112 эмч, эмнэлгийн ажилтан хорогдуулсан цагаар ажилласан ба 234 эмч эмнэлгийн ажилтанд хэвийн бус нөхцөлийн 10%-ийг</p>	100

						олгосон. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчин бүртгэгдээгүй.	
	37	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг бүртгэн мэдээлэх, эмнэлгийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулах	Үйлчлүүлэгчд ийн сэтгэл ханамж	90%	95%	ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь 1 ёс зүйн салбар хороо, 2 хэсгийн хороо, 6 багийг арга зүйгээр ханган ажилласан. Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тайлант хугацаанд 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1024, багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Эмч, сувилагч нарын мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, сурталчлах үйл ажиллагааны хүрээнд ажил мэргэжлийн уралдаан 1, хэлэлцүүлэг 1, телевизийн 3 нэвтрүүлэг, 2 аян, 1 хөрөг нэвтрүүлэг бүтээж, шилдэг 3 байгууллагыг шалгаруулсан. Тайлант хугацаанд ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд гомдол ирээгүй. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 95% байна.	100
4.Ерөнхий чиг үүргийн нэр: Эрүүл мэндийн мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага							
Үндсэн чиг үүргийн нэр: Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийг нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх , шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглах							
Зорилт 1. Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, үйл ажиллагааг өргөжүүлэх	38	“Эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын журам”-ыг хэрэгжүүлэх, хяналт тавих	Хэрэгжилтийн хувь	82%	85%	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газрын албан ажлын хэрэгцээнд төрийн байгууллагын цахим шуудангийн үйлчилгээг эрүүл мэндийн цахим мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг ханган Үндэсний дата төвийн төв серверт байршуулан ашигласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, амбулатори, тасаг, нэгжийн үйлчилгээнд цахим бүртгэл, мэдээлэл, хяналтын орчин нөхцөлийг бүрдүүлж, иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний менежментийг сайжруулах, шуурхай, ил тод нээлттэй байдлыг хангах, тусламж үйлчилгээний чирэгдлийг бууруулах зорилгоор “Цахим эрүүл мэнд” төслийг хэрэгжүүлсэн. Төсөл хэрэгжүүлснээр БОЭТ-д шаардлагатай сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр иж бүрэн Firewall сервер, сүлжээний төхөөрөмжүүд, IP камер, windows surface tablet зэрэг	87,5

						тоног төхөөрөмжүүдийг худалдан авч суурилуулан ашиглаж байна. Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын стандарт журмын хэрэгжилт 70% байна.	
39	Орон нутагт хийгдэх алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Алсын зайн оношилгооны тоног төхөөрөмжийн хангалтын хувь	33%	40%	<p>Бүсийн оношилгооны төвд суурилагдсан зайн оношилгооны телемедициний хурлын төхөөрөмжөөр 134 хурал, сургалт семинар зохион байгуулагдаж 512 холбогдох удирдлага эмч, мэргэжилтэн хамрагдсан. Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна. Тайлант хугацаанд БОЭТ-ийн телемедициний алсын зайн оношилгоо, техник тоног төхөөрөмжөөр уушги, зүрх судасны өвчний эмгэгийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2 удаа холбогдож оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Lifesize программыг нэвтрүүлж, нэвтрэх эрхийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн нь телемедицинийг гар утаснаасаа алсын зайн оношилгоо эмчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Жаргалант сумын эрүүл мэндийн төвд тус төсөл үргэлжлэн хэрэгжиж байгаа бөгөөд тайлант хугацаанд мобайл тусламж үйлчилгээг 165 өрхөд 355 хүнийг хамруулсан. Эрүүл мэндийн яаманд мобайл технологийн төсөлд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын судалгаа болон тус төсөлд хамрагдах 2 өрхийн эрүүл мэндийн төвийн судалгааг хүргүүлсэн байна.</p> <p>“Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 20 ширхэг планетаар хангаснаар түргэн тусламжийн дуудлага болон өрхийн гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч тухайн иргэний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэл шивэлт хийх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухай бүрт нь бичиж хүлээгдэл, чирэгдлийг бууруулсан бөгөөд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 95%-д хүрсэн. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалтыг 37,9%-тай, суурь үзүүлэлтээс 16%-аар нэмэгдсэн байна.</p>	70	

	40	Эрүүл мэндийн мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллуулах	Сургалтад хамрагдсан тоо	50%	90%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн мэдээлэл технологийн 7 мэргэжилтнийг ЭМХТ-өөс мэдээллийн аюулгүй байдал, CSS, HTML 5 програмчлал, техникийн даалгавар боловсруулах талаар чадавхжуулах сургалтад хамруулсан.	70
	41	Эрүүл мэндийн байгууллагуудыг шилэн кабельд үе шаттайгаар холбож, интернетийн хурдыг сайжруулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг хангаж ажиллах	Шилэн кабельд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын тоо	10	12	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн 168 байгууллага интернетийн сүлжээнд 100% холбогдсоноос 13 эрүүл мэндийн байгууллага <u>Юнивишн, Мобинет ХХК</u> -ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн <u>кабелийн</u> интернетийн сүлжээнд холбогдсон. Интернетийн хурд сайжирснаар өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн цахим програмуудыг өндөр хурдны интернетийн сүлжээгээр ашиглаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг ханган ажилласан. <u>БОЭТ</u> , сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цахим бүртгэлийн E-Health, E-Clinic, Hinfo, дархлаажуулалт, хөнгөлөлттэй эмийн жор бичих health.gov.mn, шинжилгээний бүртгэлийн eguul.gov.mn болон вакцины гэрчилгээ, шинжилгээний хариу авах, <u>БОЭТ-д</u> үзлэгийн цаг захиалахад E-Mongolia.mn системүүдийг тус тус ашиглаж ажилласан.	100
Зорилт 2. Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэрэглэгчдийн шаардлагыг хангасан эрүүл мэндийн мэдээллээр хангаж,	42	Эрүүл мэндийн ажилтнуудыг компьютерийн хэрэглээ болон мэдээллийн сүлжээний ашиглалтын анхан болон ахисан түвшний сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь	-	50%	Олон улсын эмнэлзүйн Uptodate цахим платформыг хэрэглэх сайжруулах хүрээнд зохион байгуулсан “Up to date программын хэрэглээг өргөжүүлэх нь” ажил мэргэжлийн уралдаанд эрүүл мэндийн салбарын 5 баг оролцсоноос тэргүүн байрыг Медипас эмнэлэг, дэд байрыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, гутгаар байрыг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын багууд тус тус эзэлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Орон нутгаас бэлтгэгдсэн 2 сургагч багш эмч нарыг цахим сургалтад үе шаттай хамруулж ажилласан. Нийт эмч нарын 62% нь тус платформд бүртгэл үүсгэж ашиглаж, өмнөх онтой харьцуулахад 8%-	100

нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих	43	Эрүүл мэндийн удирдах статистик мэдээлэлд шинжилгээ ашиглах бэхжүүлэх	мэндийн ажилтны мэдээ, дүн хийх, чадварыг	Сургалтад хамрагдсан удирдах ажилтны хувь	-	90%	аар нэмэгдсэн. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан статистик мэдээний чанар сайжруулах 2 удаагийн цахим сургалтад өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн 13 ортой эмнэлгийн бүртгэл статистикийн ажилтнууд, байгууллагын дарга нарыг хамруулсан.Удирдах ажилтны 84,6%-ийг хамруулсан байна.	94
	44	Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээ мэдээллийн үнэн, зөв, шуурхай байдлыг ханган ажиллах		Мэдээний чанар	90%	92%	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 168 байгууллагаас үйл ажиллагааны чиглэлээр сар бүр албан ёсны мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу 143 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн, мэдээлсэн. Байгууллагуудын мэдээний чанарт хуваарийн дагуу 4 удаа цахим хяналт хийж, үнэлгээ дүгнэлт өгч, зөрчлийг арилгуулан зөвлөмж өгч ажилласан. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн 69 эмнэлэг, клиникээс 6 байгууллага тодорхой шалтгааны улмаас ажиллаагүй, мэдээний ирц 78 хувьтай, хувийн хэвшлийн 81 эмийн сангийн мэдээний ирц 60.4 хувь байгаа ба эргэн мэдээллээр хангаж, сарын мэдээг хугацаа хоцроосон 25 байгууллагад албан тоот хүргүүлснээр мэдээний өгөлт 2 хувиар нэмэгдсэн. Тайлант хугацаанд 56 клиник, Эрдэнэт медикал, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, ор бүхий 10 клиникт хяналт хийж, ЭМС-ын 2019 А/611 тушаалын дагуу статистик мэдээний чанар сайжруулах, анхан шатны маягт шинэчлэх зөвлөмж хүргүүлсэн. Өрхийн эрүүл мэндийн төвийн цахим бүртгэлд 10 удаа хяналт хийгдсэнээс кодлолт бүрэн гүйцэд бус 756, эмчийн үзлэгийн бүртгэлийг алдаатай буруу сонгож бүртгэсэн 5822 алдаа зөрчлийг илрүүлснээс 78.7 хувьд E-hospital програмаас Hinfo програм руу хөрвүүлэх явцад гарсан алдааг илрүүлэн дүгнэлт зөвлөмж өгөн засуулж, зөрүүг арилгасан. Мэдээ өгөлт 84%, мэдээний чанар 94% байна.	100
5. Ерөнхий чиг үүргийн нэр: ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ								
Үндсэн чиг үүргийн нэр: Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах								
Эрүүл мэндийн байгууллагыг	45	Эдийн засгийн тооцоо, төсөөллийг улс орны	Эдийн засгийн		1	1	Улс, орон нутгийн эдийн засгийн нөөц бололцоог тулгуурлан хөрөнгө оруулалтын судалгааг дэлгэрэнгүй	100

санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, мэдээ тайланд хяналт тавих		санхүүгийн нөөц бололцоотой уялдуулан төлөвлөх	тооцоо, төсөөлөл			гаргаж төлөвлөн, нэн шаардлагатай байгаа их засвар, тоног төхөөрөмжийн судалгааг эрэмбэлэн 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтыг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Тайлант хугацаанд нийт 5,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс ЭМЯ-наас 2,2 тэрбум, орон нутгаас 1,9 тэрбум, төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагаас 159,5 сая, хандив, зээл тусламжаар 885,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдсэн байна.	
	46	Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуульд заасныг мөрдлөг болгон ажиллах	Өр авлага үүсээгүй байна	-	-	Төсвийн тухай хууль, 2022 оны Төрийн хэмнэлтийн тухай хуулиудын дагуу эрүүл мэндийн салбар байгууллагууд 2022 оны батлагдсан төсөвт багтаан өр төлбөр, авлагагүй ажилласан. Орон нутгийн нэгтгэл хамаарагддаг өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сумын эрүүл мэндийн төв 2022 оны байдлаар өр төлбөргүй, батлагдсан төсөвт багтаан ажилласан. 2021 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагууд нийт 33,9 сая төгрөгийн авлагатай байснаас 2022 оны 04 дүгээр сард Сангийн яамнаас 5,0 сая төгрөгийн авлагыг, 05 дугаар сард хувь хүнтэй холбоотой үүссэн 81,1 мянган төгрөгийн авлагыг бүрэн авч авлагыг барагдуулан ажилласан. 28,4 сая /ЭМГазарт-5,0 сая, БОЭТ-д 23,4 сая/ төгрөгийн авлага нь он дамжин ирсэн /татан төвлөрүүлсэн үлдэгдэл, Эрүүл монгол хүүхэд аяны эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт/ төлөгдөх нь тодорхойгүй авлагууд байна.	100
	47	Эрүүл мэндийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны маягт хөтлөлтөд хяналт тавьж ажиллах	Хяналтад хамрагдсан ЭМБ-ын хувь	60%	100%	Тайлант хугацаанд гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны маягт Сангийн сайдын баталсан 314 дүгээр журмын дагуу бүрэн хөтлөгдсөн, үндсэн хөрөнгийн анхан шатны баримт хөтлөлт бүх эрүүл мэндийн байгууллагын хувьд жигд сайн, хөрөнгийн тооллого хугацаандаа хийгдсэн байна. Санхүүгийн аудитад хамрагдсан зохих 11 байгууллагаас 11 байгууллага хамрагдсан.	100
Бүх шатны эмнэлэг, эрүүл	48	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг	БОЭТ-ийн тоног	75%	80%	- Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн 297,2 сая төгрөгийн санхүүжилтээр 4 нэр төрлийн 34	100

мэндийн байгууллагуудыг барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэх		шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах	төхөөрөмжийн хангалтын хувь			ширхэг зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийн дэмжих төвд улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 34 нэр тоног төхөөрөмжөөр ханган урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн насанд хүрэгчдийн багцын үзлэг хийж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 92 хувь болж өмнөх онтой харьцуулахад 2%-аар нэмэгдсэн.	
	49	БОЭТ-ийн шаардлагатай тасаг нэгжид барилга их засвар хийх, гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан кабель шугамыг шинэчлэх	Үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл сайжирсан тасаг нэгжийн тоо	3	Амбулаторийн засвар Эмгэг судлалын тасгийн цогцос хадгалах байрны өргөтгөл Инженерийн шугам сүлжээ, цахилгаан кабелийн шугамын шинэчлэл	Орон нутгийн 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амбулаторийн 1 болон 2 давхрын их засварын ажил бүрэн хийгдэж дууссан. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн цахилгаан кабель шугамыг шинэчлэхэд 135,0 сая, гадна инженерийн шугам сүлжээний засварт 150.0 сая төгрөгийн ажлууд батлагдаж орон нутгийн Өмчийн газар гүйцэтгэгч компани болох “Аривлах” ХХК болон гэрээт “Маут Консалтинг” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл 100% байна Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмгэг судлалын тасгийн цогцос хадгалах байрны өргөтгөлийн барилгын гүйцэтгэл 100% байна.	100
	50	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, чадавхыг бэхжүүлэх	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	85%	90%	Тайлант хугацаанд орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 өрхийн эрүүл мэндийн төвийг билиметр болон УВЧ аппаратаар хангахаар “Мед Буян” ХХК шалгарч нийлүүлэгдсэн. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-д хүрч, өмнөх онтой харьцуулахад 13%-аар нэмэгдсэн.	100

6.Ерөнхий чиг үүргийн нэр: Эрүүл мэндийн салбарын удирдлагын манлайлал, ил тод байдал

Үндсэн чиг үүргийн нэр: Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт ил тод байдлыг ханган, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулах.

Зорилт 1. Хүн	51	Эрүүл мэндийн	Гэрээний	88,3%	90%	Хувийн хэвшлийн Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг	97
---------------	----	---------------	----------	-------	-----	--	----

<p>амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулах.</p>		<p>байгууллагуудтай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулж, дүгнэн ажиллах.</p>	<p>хэрэгжилтийн дундаж хувь</p>		<p>болон ор бүхий 11 клиниктэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газартай гурвалсан гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж хагас бүтэн жилээр үнэлэхэд бүрэн хангалттай, хангалттай сайн үнэлэгдсэн. Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Ачит, Бадархундага, Очир-Увидас клиникийг <u>ковидын тусгаарлах эмнэлгээр</u> ажиллуулж 2 удаа эмнэлгүүдийн халдвар хамгаалал, эмчилгээ, оношилгоо, шинжилгээний стандарт мөрдөлт, өвчтөн шилжүүлэх журмын хэрэгжилтэд үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан ба зөвлөмжийн хэрэгжилт 96%-тай байна. Хувийн хэвшлийн төрөлжсөн болон дотор, мэдрэлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг 10 ор бүхий клиникт хяналт хийхэд “Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны MNS5095:2017” стандартын хэрэгжилт 96,5%, уламжлалтын тусламж үйлчилгээ үзүүлдэг 2 ор бүхий клиникт “Уламжлалтын анагаахын нэгдсэн эмнэлгийн MNS5700:2020” стандартын хэрэгжилт 98%-тай үнэлэгдсэн. Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/85 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг ортой эмнэлгүүдийн орны стандарт хэмжилт, хүний нөөцийн хангалт, халдварын сэргийлэлт хяналт, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд үнэлгээ хийхэд нийт эмнэлгүүдийн 83.3.% нь стандартын шаардлага хангасан өөрийн эзэмшлийн байранд үйл ажиллагаа явуулж, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг 97% хангасан байна. 49 эмийн санд “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд дунджаар 90,1% үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,4%-аар сайжирсан байна. “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих шаардлага MNS5530:2014 стандарт”-аар 6 байгууллагад хяналт хийхэд дунджаар 93,4% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 5,3%-аар сайжирсан байна.</p>	
	52	<p>Эрүүл мэндийн байгууллагыг шинээр байгуулах, хүчин чадлыг</p>	<p>Эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд</p>	16	<p>гүйцэтгэлээр Тайлант хугацаанд эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 5 удаа хуралдан тусгай зөвшөөрлийг шинээр 14 байгууллагад олгосон байна.</p>	100

		нэмэгдүүлэхдээ хүн амын тоо, газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлог, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, судалгаанд тулгуурлан зохион байгуулах.	тулгуурлан шинээр байгуулагдсан байгууллагын тоо			Монгол улсын Засгийн газрын 2022 оны 138 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын “Эрдэнэт медикал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байгуулагдаж, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг ЭМЯ-наас олгосон. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвд улс болон орон нутгаас нийт 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээс орон нутгаас их засварын ажилд 289,0 сая төгрөг, улсын төсвөөс их засварт 180,0 сая, багаж тоног төхөөрөмжид 1,5 тэрбум төгрөгийн үзлэг шинжилгээ болон оношилгооны 34 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагааг тогтмолжууллаа. Түргэн тусламжийн төвийн 6 эмч, жолоочийн цалин, шатахуунд аймгийн Засаг даргын 2022 оны А/33 дугаар захирамжаар 285,0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.	
53	Хоёр болон олон талт хамтын ажиллагааг салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх	Тулгамдсан асуудлыг шийдэхэд оруулсан хөрөнгө оруулалт	71,6 сая	гүйцэтгэлээр	Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт, тусламжаар 2 төсөл хэрэгжиж, хэрэгжилт 100% байна. Тус 2 төслийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулсан. Тус төслүүдийн хүрээнд: ЭМЯ, ЭМХТ, Жайка Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд 2018-2020 онд 9, тайлант хугацаанд 3 резидент эмч суралцаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс сувилахуйн чиглэлээр сургалт эрхлэх хүсэлт гаргасны дагуу сургалтын эрх шинээр олгох үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Жайка Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хийж зөвлөмжийг ирүүлснээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 16 сувилагч элсэн суралцаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх контент бэлтгэх, хөгжүүлэх, түгээх нь” төсөл 100%-тай хэрэгжсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Яаралтай түргэн	100	

						тусламжийн тасагт олон улсын буцалтгүй тусламжаар 247,9 сая төгрөгийн амьсгалын аппарат 6 ширхэг, Европын холбооны байгууллагын буцалтгүй тусламжаар 14,3 сая төгрөгийн эрчимт эмчилгээний 5 ширхэг ор, нийт 262,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж үйл ажиллагаанд ашиглагдсан.	
Зорилт 2. Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх	54	Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх	Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын тоо	2	Гүйцэтгэлээр	Тайлант хугацаанд төрийн үйлчилгээг 9 байгууллага гэрээгээр гүйцэтгэж ажилласан байна. Үүнд: - Аймгийн Засаг даргын 2021 оны А/396 дугаар захирамжаар зуны сувиллын үйл ажиллагаанд 20,0 сая төгрөгийг шийдвэрлэснээр <u>Бүжинлхам</u> хувийн хэвшлийн клиник нь дутуу болон бага жинтэй нярайг торниулах, 0-5 хүртэлх насны өсөлт бойжилтын хоцрогдол, хоол тэжээлийн дутагдалтай, "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын халдвар аваад эдгэрсэн (тураал, өсөлтийн хоцрогдол, туранхай, цус багадалт, сульдаа, хөгжлийн бэрхшээлтэй) 150 хүүхдийг эмчлэх, сувилах, сэргээн засах зуны гэр сувилалд хамрууллаа. <u>Чийрэгжүүлэлт</u> , сувилгаанд хамрагдсан хүүхдүүдийн 82,5%-д 100-500 гр жин нэмэгдэж, эмнэлзүйн хувьд хооллолтын бэрхшээл арилсан үр дүнтэй байна. - <u>Орхон</u> аймгийн Ахмадын холбоо, Эрдэнэт үйлдвэр <u>ТӨҮГ-ын</u> Ахмадын хороо, Мөнхийн үйлс эмнэлэг хамтран <u>ковидын</u> дараах сэргээн засах тусламж үйлчилгээг 478 ахмадад үзүүлсэн байна. - <u>Коронавируст</u> халдварын цар тахлын үед ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг 8 байгууллагатай аймгийн Засаг дарга гэрээ байгуулж ажилласан ба нийт 20,740м ² талбайн <u>халдваргүйтгэлийг</u> хийсэн байна.	100
	55	Нэг дороос бүх төрлийн тусламжийг авах нөхцөлийг бүрдүүлсэн төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын	Төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлж буй байгууллага	2	3	Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 92157 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 16.7%-ийг, 16322 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 50,9%-ийг эзэлж Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын	100

		чадавхыг нэмэгдүүлнэ				хурлын шийдвэрээр “Талын булаг” ор бүхий клиникт дүрс оношилгооны, Очир-Увидас уламжлалт сэргээн засах клиникт дотрын тусламж үйлчилгээний чиглэл, Ачит клиникт мэдрэлийн өвчний тусламж үйлчилгээний чиглэл, Эко эмийн санд 24 цагийн үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээг нэмж олгосон. “Шинэ эрин мед” клиникт “ЭХО Туяа” оношилгоо, “Теку анка” дотрын клиникийг нэгтгэж төрөлжсөн мэргэжлийн клиник болгож өргөжүүлсэн. Баян-өндөр Мед нэгдсэн эмнэлэгт хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлэхээр хүний нөөцийг сургаж, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний 10 орыг нэмэлтээр олгосон. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эмнэлгүүд амбулатори, өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээгээр даатгалын сонгон шалгаруулалтад тэнцэж, өмнөх онтой харьцуулбал 3 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн ажилласан.	
Зорилт 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн	56	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод байдлыг хангахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод байдалд өгсөн иргэдийн үнэлгээ	81,7%	90%	Эрүүл мэндийн чиглэлээрх төрийн бодлого, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, стратеги, хууль, эрх зүй, мэдээ мэдээлэл, ил тод байдал, шилэн данс, байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг ил тодоор or.mohs.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан тухай бүр шинэчлэн ажилласан. Эрүүл мэндийн газар /www.or.mohs.gov.mn/ , Бүсийн оношилгоо эмчилгээний төв /www.orkhonboet.moh.gov.mn/ зэрэг байгууллагууд байгууллагын вэб сайттай бөгөөд бусад эрүүл мэндийн байгууллагууд facebook page хуудас ажиллуулан мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан. Тайлант хугацаанд /www.or.mohs.gov.mn/ Эрүүл мэндийн газрын вэб хуудсыг шинэчилсэн. Мөн Орхон аймгийн Эрүүл мэндийн газар Facebook page хуудсыг тогтмол ажиллуулж иргэдэд эмнэлгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж ажилласан бөгөөд тус пэйж хуудсыг 12798 нийт дагаж байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар үеийн арга хэмжээний талаар	100

					нийт 1550 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Мөн эрүүл мэндийн салбарын хэмжээнд нээлттэй хаалганы өдөр 7, аян 10, өдөрөлг 24, арга хэмжээ 16 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 88157 иргэнийг хамруулсан. E-Times сайттай албан ёсны гэрээ байгуулж хамтран ажилласан. Тусгай зөвшөөрөл олголтын ил тод байдлыг хангах хүрээнд www.erdenet.mn , or.mohs.gov.mn сайтын ил тод цэсэд тусгай зөвшөөрөлтэй ажиллаж байгаа 181 байгууллагын мэдээлэл, 2022 оны байдлаар тусгай зөвшөөрөл авсан, цуцлагдсан, эрх сэргээсэн байгууллагын мэдээллийг байршуулсан. E Mongolia системд тусгай зөвшөөрөл сунгуулах байгууллагуудын хүсэлт материалыг хүлээн авах, архивлах, шийдвэрийг хүргүүлэх чиглэлээр төрийн үйлчилгээг шинээр оруулж хандах эрх авсан. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллаа болон олон улсын төсөл хөтөлбөрийн чиглэлээр эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл хэрэгжүүлж буй үйл ажиллагааг мэдээллийн самбар болон цахим хуудсаар сурталчлан хамтран ажилласан. <u>Тусламж үйлчилгээний ил тод байдалд иргэдийн сэтгэл ханамж 96%-тай байна.</u>	
57	Аймаг, орон нутгийн батлан хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, дэд хөтөлбөрүүдийг иргэд олон нийтэд хүргэх, зохион байгуулж буй үйл ажиллагааг иргэд олон сурталчлах	Сурталчилсан тоо	12	50%-аар нэмэгдсэн байна.	<u>НЭМТ-ийн студид 108 эх бэлтгэл, 42 зөвлөмж нэвтрүүлэг, 4 подкаст, 126 уриалга шторк, 156 сурвалжилга болон цахим хуудаст 320 төрлийн бэлтгэн цахим сүлжээгээр дамжуулан давхардсан тоогоор 640225 иргэдийг мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр хангасан нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</u>	100
58	Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг ил тод цахимжуулах, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах	Цахимжуулсан үйлчилгээний тоо	-	1-2	Цахимаар үзүүлж буй үйлчилгээний талаар erdenet.mn , or.mohs.gov.mn , <u>Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээ мэдээллийг байршуулан, иргэдэд түгээсэн. Цахимаар:</u> -Төрийн үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia" системээс <u>коронавируст</u> халдвараас сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн вакцины гэрчилгээ авах - <u>Коронавируст</u> халдвараар өвчлөөд эдгэрсэн тухай	100

						эмнэлгийн лавлагаа авах, -Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ авах, лабораториудад өгсөн шинжилгээний хариу авах Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргах үйлчилгээг шинээр нэмж оруулсан.	
59	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүх хэлбэрээр авч, шийдвэрлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх	Шийдвэрлэлт ийн хувь	100%	100%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой цахимаар 37, бичгээр 27, нийт 64 хүсэлт, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр шийдвэрлэсэн. Нийт ирүүлсэн өргөдөл, хүсэлт, гомдлын 96,9%-ийг хүсэлт, 3,1%-ийг гомдол тус тус эзэлж байна. Эрүүл мэндийн газарт ирүүлсэн хүсэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56,1%, гомдол 3,5 дахин буурсан үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтэд дотоод хяналт хийж зөвлөмжөөр ханган ажилласан. Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл АЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэж мэдээлэгдэж, Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг ханган ажилласан.	100	
Хэрэгжилтийн дундаж хувь-96,7%							

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ